



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/100

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бат-Өлзий сумын Бүрэгтий багийн Бугатын хэжүүгийн зам засварын ажлыг 18,800,000 (арван найман сая найман зуун мянга) төгрөг, Улаан-Ам багийн Хөнөгийн голын гүүр засварлах ажлыг 19,000,000 (арван есөн сая) төгрөгөөр тус тус “Хан сэнтий” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2. “Хан сэнтий” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, зам засварын ажлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Бүрэгтий багийн Бугатын хэжүүгийн зам засварын ажлын 18,800,000 (арван найман сая найман зуун мянга) төгрөг, Улаан-Ам багийн Хөнөгийн голын гүүр засварлах ажлын 19,000,000 (арван есөн сая) төгрөгийн санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН